



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ДЭД САНГААС САНХҮҮЖҮҮЛСЭН ТӨСЛҮҮД  
ХЭРЭГЖИЖ БАЙГАА Ч ТӨЛӨВЛӨСӨН АЖЛЫН БАЙРЫГ ХАНГАЛТТАЙ БИЙ БОЛГООГҮЙ  
БАЙНА.**



**АУДИТЫН НЭР:** ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ САНГИЙН ҮР ДҮНД АЖЛЫН БАЙР  
НЭМЭГДСЭН БАЙДАЛ  
**АУДИТЫН КОД:** АРА-2020-/02/-ГА

**Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга  
бөгөөд Тэргүүлэх аудитор Д.Уламбаяр**  
Утас:7033-3141 Цахим хаяг: [Ulambayard@audit.gov.mn](mailto:Ulambayard@audit.gov.mn)

Цэцэрлэг хот  
2020 он

**Аудитын менежер Т.Байгалмаа**  
Утас: 7033-2860 Цахим хаяг: [Baigalmaat@audit.gov.mn](mailto:Baigalmaat@audit.gov.mn)

**ГАБ-ийн ахлагч, Ахлах аудитор Д.Нэргүйбаатар**  
Утас: 7033-3019 Цахим хаяг: [Nerquibaatar@audit.gov.mn](mailto:Nerquibaatar@audit.gov.mn)

**ГАБ-ийн аудитор Г.Цог-Эрдэнэ**  
Утас: 7033-3019 Цахим хаяг: [Tsoq-erdeneg@audit.gov.mn](mailto:Tsoq-erdeneg@audit.gov.mn)

Энэхүү тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу. Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)



<p><u>Тайлан бэлтгэсэн:</u></p> <p>Архангай аймаг дахь Төрийн аудитын газар</p> <p>Тэргүүлэх аудитор: Д. Уламбаяр</p> <p>Аудитын менежер: Т.Байгалмаа</p> <p>Ахлах аудитор: Д.Нэргүйбаатар</p> <p>Аудитор: Г.Цог-Эрдэнэ</p> <p>2020 оны 07 дугаар сар</p> <p>Уг тайланг УАГ-ын Веб сайт-аас үзнэ үү.</p> <p>www.audit.mn</p> <p><i>Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70332860 дугаарын утас, 70333141 дугаарын факсаар харилцана уу</i></p> <p>ХАЯГ: Эрдэнэбулган сум Аймгийн ЗДТГ-ын байр 3-р давхар 311 тоот</p>	<p><b>ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ .....</b></p> <p><b>АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ ....</b></p> <p><b>БҮЛЭГ 1.</b> ХЭД дэд сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.</p> <p>1.1. Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний төсвийг зориулалтын дагуу зарцуулсан байна.</p> <p>1.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд баталсан төсвийг зориулалтын дагуу зарцуулсан ч анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байна.</p> <p><b>БҮЛЭГ 2.</b> Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжүүлсэн төслүүд төлөвлөсөн байнгын ажлын байр бодитоор бий болсон нь нотлогдохгүй байна.</p> <p>2.1. Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний үр дүнд 2018, 2019 онуудад шинээр 1290 ажлын байр бий болсон мэдээлэлтэй байна.</p> <p>2.2. ХЭҮЗ-өөс баталсан хөтөлбөрүүдийг хэрэгжүүлснээр төлөвлөсөн ажлын байр нэмэгдэж бодит үр дүн бий болсон нь нотлогдохгүй байна.</p> <p><b>БҮЛЭГ 3.</b> Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сангийн санхүү, хөтөлбөрийн хэрэгжилтэнд хийсэн дотоод хяналтын үр нөлөө хангалтгүй байна.</p> <p>3.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сангийн хөрөнгийн зарцуулалт, эргэн төлөлтөнд дотоод хяналтыг хэрэгжүүлсэн боловч үр нөлөө нь хангалтгүй байна.</p> <p>3.2. Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн баталсан хөтөлбөрийн хэрэгжилтэнд аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлөөс хяналт тавих үүргийг хэрэгжүүлээгүй байна.</p> <p><b>ДҮГНЭЛТ.....</b></p> <p><b>ЗӨВЛӨМЖ.....</b></p> <p><b>ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ .....</b></p> <p><b>ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ</b></p> <p><b>ХАВСРАЛТУУД</b></p>	<p>3</p> <p>4-6</p> <p>7-9</p> <p>9-11</p> <p>11-12</p> <p>13-18</p> <p>19</p> <p>20</p> <p>21</p> <p>22</p>
--	--	--



## ***Товчилсон үгийн жагсаалт***

<b>ААНБ</b>	Аж ахуй нэгж, байгууллага
<b>АРА</b>	Архангай аймаг
<b>БЗД</b>	Багийн Засаг дарга
<b>ЕБС</b>	Ерөнхий боловсролын сургууль
<b>МСҮТ</b>	Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв
<b>НДХ</b>	Нийгмийн даатгалын хэлтэс
<b>НДШ</b>	Нийгмийн даатгалын шимтгэл
<b>СЗД</b>	Сумын Засаг дарга
<b>ТББ</b>	Төрийн бус байгууллага
<b>ХБИ</b>	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
<b>ХНХС</b>	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
<b>ХНЗ</b>	Хөдөлмөр нийгмийн зөвшилцөл
<b>ХХҮГ</b>	Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар
<b>ХХҮЕГ</b>	Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар
<b>ХЭДС</b>	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
<b>ХЭЗ</b>	Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөл
<b>ХЭҮЗ</b>	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл



## АУДИТЫН ЗОРИЛТ, АРГА ЗҮЙ, СТАНДАРТЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

### АУДИТ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ, БҮРЭН ЭРХ:

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын 2019 оны А/100 дугаар тушаалаар баталсан "...2020 онд гүйцэтгэх аудитын сэдвийн төлөвлөгөө"-г үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон орон нутгийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

### АУДИТЫН ЗОРИЛТ:

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сангийн үйл ажиллагааны үр дүнд ажлын байр нэмэгдсэн байдалд аудит хийж дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулах, орон нутгийн удирдлагууд болон олон нийтийг бодит мэдээллээр хангахад аудитын зорилт чиглэгдлээ. Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг хийлээ. Үүнд:

- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сангийн хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулсан уу
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны үр дүнд байнгын ажлын байр нэмэгдсэн үү
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сангийн санхүү болон хөтөлбөрийн хэрэгжилтэнд тавих дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлсэн үү

### АУДИТЫН ХАМАРСАН ХҮРЭЭ:

Аудитаар аймгийн ХХҮГ-ын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сангийн 2018, 2019 оны хөрөнгийн зарцуулалтыг түүвэрлэн, ХЭҮЗ-ийн баталсан хөтөлбөрүүдийн хүрээнд санхүүжүүлсэн төслийн хэрэгжилт үр дүн, ажлын байр нэмэгдсэн байдлыг хамруулан шалгалаа. Мөн ХЭДСангаас 2018, 2019 онд эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг авсан иргэдийн эргэн төлөлт, төслийн хэрэгжилт, үйл ажиллагааны үр дүнг түүвэрт хамруулан шалгалаа.

### АУДИТЫН АРГА ЗҮЙ:

Төрийн аудитын стандарт MNS 6817:2020 стандарт, гүйцэтгэлийн аудитын удирдамж (АДБОУС 3000-3100), гүйцэтгэлийн аудитын журмыг ашиглан төрийн байгууллага, нэгжийн холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, асуулга, лавлагаа, судалгаа, тодруулга авах, ХЭДС-ийн хөрөнгийн зарцуулалтыг түүвэрлэн, үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, ХЭДС-аас санхүүгийн дэмжлэг авч хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний хэрэгжилт, бусад шаардлагатай баримт материалд дүн шинжилгээ хийх зэргээр Тэргүүлэх Аудиторын баталсан аудитын төлөвлөгөөний аргазүйг ашиглан аудитын хөтөлбөр горимын дагуу шаардлагатай нотлох зүйлсийг цуглуулав.

### АУДИТАД АШИГЛАСАН ХУУЛЬ ТОГТООМЖ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ:

- Төсвийн тухай хууль
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль
- ХЭДС-ийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих, үйл ажиллагаанд мөрдөх журам /МУЗГ-ын 2011 оны 350 дугаар тогтоол/
- ХЭДС-аас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам /МУЗГ-ын 2016 оны 276 дугаар тогтоол/
-



- Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн дүрэм /МУЗГ-ын 2011 оны 350 дугаар тогтоол/
- Аймаг, нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлийн дүрэм /ХЭҮЗ-ийн 2017 оны 02-р тогтоол
- ХЭҮЗ-ийн 2017 оны 01-р тогтоол /ХЭДС-аас хэрэгжүүлэх 2017-2018 оны хөтөлбөрүүд батлах тухай/
- ХЭҮЗ-ийн 2019 оны 01-р тогтоол /ХЭДС-аас хэрэгжүүлэх 2019-2020 оны хөтөлбөрүүд батлах тухай/
- ХЭҮЗ-ийн 2017 оны 03 дугаар тогтоол /Орон нутгийн онцлогт нийцүүлсэн зорилтот төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх тухай/
- Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/26, 2019 оны А/83 дугаар тушаалууд
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн актууд

#### ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ:

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийг 2011 онд шинэчлэн найруулж баталснаар Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан байгуулагджээ.

Тус сангийн тухайн жилийн төсвийн хуваарийг Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн саналыг харгалзан ХНХСайд баталж байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг хуульд заасан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 11 үйл ажиллагаанд зарцуулах бөгөөд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанаас өөр зориулалтаар ашиглахыг хориглосон байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг төсөл хөтөлбөрийн хэлбэрээр хэрэгжүүлэх бөгөөд төсөл, хөтөлбөрийг Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл /ХЭҮЗ/ баталдаг. Тус зөвлөл нь хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлийн дүрмийг баталж мөрдүүлдэг байна. ХЭҮЗ-ийн баталсан дүрэмд зааснаар хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөл нь аймгийн Засаг даргын орлогчоор ахлуулсан орон тооны бус нийт 7 гишүүнтэйгээр ажиллах бөгөөд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сангийн орлогын байдалд хяналт тавих, аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны явц, үр дүнд үнэлгээ хийж тайланг ХЭҮЗ-д хүргүүлэх зэрэг үүрэгтэй ажээ.

Аймгийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага буюу ХХҮГ нь хөдөлмөрийн тухай хууль, тогтоомж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний хэрэгжилтийг орон нутагт зохион байгуулах, хяналт тавих үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

Аймгийн ХХҮГ-ын ХЭДС-ийн санхүүгийн тайлан тодруулгаас харахад 2018 онд 4096 хүн хамруулж 1559.8 сая төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 3867 хүн хамруулж 1503.7 сая төгрөг зарцуулжээ. Харин 2019 онд 4281 хүн хамруулж 1873.6 сая төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 3890 хүн хамруулж 1661.8 сая төгрөгийг зарцуулжээ.

Аудитаар хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд зарцуулсан хөрөнгийг түүвэрлэн шалгаж, ХЭҮЗ-өөс баталсан



ажлын байрыг дэмжих, залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих, малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ХБИ-ний ажлын байрыг дэмжих, Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрүүдийн болон орон нутгийн онцлогт нийцсэн хөтөлбөрийн хүрээнд олгосон санхүүжилтийн эргэн төлөлт, санхүүжилт авсан төслийн хэрэгжилтийг түүвэрлэн газар дээр нь үзэж шалгалаа.

Аймгийн дэд сангаас 2018 онд нийт 194 иргэнд 900.0 сая төгрөгийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгож, 2020 оны 6 сарын байдлаар 194 иргэн 573.6 сая төгрөгийг буцаан төвлөрүүлэхээс 114 иргэн 309.5 сая төгрөгийг бүрэн төвлөрүүлсэн. Харин 80 иргэний 264.2 сая төгрөг дутуу эргэн төлөгдөх хугацаа хэтэрсэн байна.

2019 онд нийт 160 иргэнд 787.0 сая төгрөгийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгож, 2020 оны 6 сарын байдлаар 160 иргэн 126.5 сая төгрөгийг буцаан төвлөрүүлэхээс 107 иргэн 91.2 сая төгрөгийг эргэн төлөх хувиарын дагуу буцаан төвлөрүүлсэн. Харин 75 иргэний 59.0 сая төгрөг дутуу эргэн төлөгдөх хугацаа хэтэрсэн байна.

Аймгийн ХХҮГ-ын Хөдөлмөрийн хэлтсийн тайлангаар 2018 онд 1408, 2019 онд 1502 ажлын байр шинээр бий болсон байна. Тус хэлтэс нь ажил олгогч байгууллагуудаас 2018 онд 1144 ажлын байрны захиалга авч 1012 иргэнийг, 2019 онд 1015 ажлын байрны захиалга авч 970 иргэнийг тус тус ажилд зуучилсан мэдээтэй байна. /Эх сурвалж: ХЭДС-ийн үйл ажиллагааны тайлан/ Хөдөлмөрийн хэлтсийн шинэ ажлын байрны энэ мэдээнд ХЭДС-аас санхүүгийн дэмжлэг авах үед бүртгүүлсэн иргэдийн мэдээлэл болон аль нэг Хөдөлмөрийн хэлтэст Архангайн харьяалалтай иргэн ажлын байртай болоход бүртгэдэг байна. Өөрөөр хэлбэл энэ мэдээ нь зөвхөн Архангай аймгийн Хөдөлмөрийн хэлтсийн үйл ажиллагааны үр дүнд бий болсон ажлын байрны мэдээ биш байна.

ХЭДС-аас санхүүжилт олгосон төслүүдэд 2018 онд 372 ажлын байр, 2019 онд 289 ажлын байр бий болгоно гэж тусгасан боловч ажил олгогчийг дэмжих урамшууллын үр дүнд 2018 онд 6 ажил олгогч 8 ажилгүй иргэнийг, 2019 онд 6 ажил олгогч нь 13 ажилгүй иргэнийг 12 сараас дээш хугацаагаар ажлын байраар хангасан, үйлдвэр дээрх сургалт зохион байгуулсан 2 ААНБ, 16 иргэнийг байнгын ажлын байраар хангаснаас өөрөөр ажлын байр бодитоор бий болсныг нотлох албан ёсны баримт материал ХХҮГ-т алга байна.

Харин 2018 онд нийтийг хамарсан ажлын дүнд 348 иргэн, 2019 онд нийтийг хамарсан ажлын дүнд 575 иргэн, бүлгийн зохион байгуулалттай ажилд 50 иргэн, зохион байгуулалттай ажлын байрыг дэмжихэд 27 иргэн нийт 652 ажилгүй иргэнийг түр ажлын байраар хангажээ.



**АУДИТ  
ХУГАЦАА**

**ХИЙХ**

Аудитыг 2020 оны 05 сарын 14-ний өдрөөс эхлүүлж, талбарын ажлыг 2020 оны 06 сарын 02-ноос гүйцэтгэж аудитын тайлангийн төслийг 2020 оны 07 сарын 10-ны дотор Тэргүүлэх аудиторт танилцуулж, аудитын тайланг 2020 оны 07 сарын 21-ны дотор аймгийн ХХҮГ-ын дарга, аймгийн Хөдөлмөрийн зөвлөлийн даргад болон аймгийн ИТХ-ын дарга, Засаг дарга нарт тус тус хүргүүлэв.

**АУДИТ ХИЙХ БАГИЙН  
БҮРЭЛДЭХҮҮН**

Аудитыг Тэргүүлэх аудитор Д.Уламбаяр хянан удирдаж, аудитын менежер Т.Байгалмаа үе шатны болон чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Д.Нэргүйбаатар, аудитор Г.Цог-Эрдэнэ нар төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.



БҮЛЭГ 1.

**ХЭД дэд сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.**

**1.1 Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний төсвийг зориулалтын дагуу зарцуулсан байна.**

Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний дараах хэлбэрүүдийн төсвийн зарцуулалтыг түүвэрлэн шалгалаа. Үүнд:

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа нь дараах төрөлтэй:

**6.1.1. Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ**

**6.1.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ**

✓ Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах

✓ Ажилд зуучлах,

✓ Нэгдсэн бүртгэл мэдээллийн үйлчилгээнд хамруулах

**1.1.1** Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээний төсвийг зориулалтын дагуу зарцуулсан ч сургалтын байгууллагуудтай байгуулсан гэрээг дүгнээгүй байна. Үүнд:

2018 оны тухайд:


Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах чиглэлээр аймгийн ХХҮГ-аас "Мөнх-Оюуны холбоос" ХХК, "Монголын ажил мэргэжлийн мэргэшсэн зөвлөхүүдийн холбоо" ТББ, "Хайрхан бүрд" ТББ-уудтай гэрээ байгуулан 10 сумын 465 иргэдийг ганцаарчилсан сургалтанд мөн 10 сумын 1070 иргэнийг бүлгийн сургалтанд хамруулж 11,821.8 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна. Дээрх 3 сургалтын байгууллагатай холбоотой анхан шатны баримт материалыг тулган шалгахад ажил гүйцэтгүүлэхээр байгуулсан гэрээг дүгнээгүй буюу гэрээний 5.2 дахь заалтыг мөрдөж ажиллаагүй зөрчил илэрлээ. Иймд зөрчлийг давтан гаргахгүй байх сургалтын байгууллагатай байгуулсан гэрээг дүгнэж, холбогдох арга хэмжээг авах талаар зөвлөмж хүргүүлж байна.

2019 оны тухайд:


Энэ чиглэлээр "Монголын хүний нөөцийн менежментийн холбоо", "Дарь овооны эзэд" ТББ-уудтай гэрээ байгуулан 11 сумын 278 иргэдийг ганцаарчилсан сургалтанд мөн 11 сумын 743 иргэнийг бүлгийн сургалтанд хамруулж нийт 7176.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосон ба дээрх 2 байгууллагатай байгуулсан гэрээг дүгнээгүй байгаа нь гэрээний 5.2 дахь заалтыг зөрчсөн тул зөрчлийг давтан гаргахгүй байх сургалтын байгууллагатай байгуулсан гэрээг дүгнэж, холбогдох арга хэмжээг авах талаар зөвлөмж хүргүүлээ.

График 1.

Ганцаарчилсан сургалтанд хамрагдсан иргэд;



Бүлгийн сургалтанд хамрагдсан иргэд:



Дээрх графикаас харахад ганцаарчилсан сургалтанд хамрагдсан иргэд 2018 оноос 40.2 хувиар, бүлгийн сургалтанд хамрагдсан иргэд өмнөх 2018 оноос 30.5 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.





**1.1.2 Ажилд зуучлах үйлчилгээний батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулсан байна.**

**2018 оны тухайд:** Ажилд зуучлах үйлчилгээг 860 иргэнд хүргэх 11,020.0 мянган төгрөгийг төсөв батлагдаж гүйцэтгэлээр 1012 иргэнд ажилд зуучлах үйлчилгээг хүргэж 10,742.6 мянган төгрөгийг зарцуулсан байна.

**2019 оны тухайд:** Мөн онд ажилд зуучлах үйлчилгээг 960 иргэнд хүргэх 11,060.0 мянган төгрөгийг төсөв батлагдаж гүйцэтгэлээр 970 иргэнд ажилд зуучлах үйлчилгээг хүргэж 10,490.4 мянган төгрөгийг зарцуулсан байна.

График 2.



**1.1.3 Нэгдсэн бүртгэл мэдээллийн болон бусад үйлчилгээний төсвийг зориулалтын дагуу зарцуулсан байна.**

**2018 оны тухайд:** Батлагдсан төсвөөр мэдээллийн сүлжээ аюулгүй байдлын чиглэлээр 8,000.0 мянган төгрөг батлагдаж 66.9 хувь буюу 5,351.8 мянган төгрөгийн гүйцэтгэл гарсан байна.

Мөн Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн хүрээний зарчим, үндсэн эрхийн хэрэгжилтэд 2,500.0 мянган төгрөг батлагдаж 2,350.5 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлд 4,000.0 мянган төгрөг батлагдаж, 3,900.0 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Зарцуулалтыг анхан шатны баримтаар тулган шалгахад хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

**2019 оны тухайд:** Мэдээллийн сүлжээ аюулгүй байдлын чиглэлээр 9,081.2 мянган төгрөг зарцуулсан байна. Мөн Хөдөлмөрийн салбарын ажилтнууд, ХНЗ-ийн 3 талт хорооны төлөвлөгөөнд тусгагдсны дагуу хийх сургалтанд 20,008.4 мянган төгрөгийг зарцуулсан байна. Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн зардалд 4,000.0 мянган төгрөг тус тус зориулалтын дагуу зарцуулжээ.

**1.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд баталсан төсвийг зориулалтын дагуу зарцуулсан ч анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байна.**

**1.2.1 Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн сургалтанд зориулсан хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан ч гэрээг дүгнээгүй байна.**

**2018 оны тухайд:** Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох чиглэлээр ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, ажлын байр үйлдвэрлэлтэй танилцах сургалтанд 105 иргэнийг хамруулж 4,725.0 мянган төгрөгийг, үйлдвэрлэл дээрх сургалтанд 7 иргэнийг хамруулж 3,360.0 мянган төгрөгийг мөн мэргэжлийн болон давтан явуулын сургалтанд 81 иргэнийг хамруулж 14,692.0 мянган төгрөгийг нийт 22,777.0 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.




2019 оны тухайд:

Дээрх чиглэлийн сургалтанд 191 иргэнийг хамруулж 34,845.0 мянган төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс 239 иргэнд нийт 34,525.0 мянган төгрөг зарцуулсныг анхан шатны баримтаар шалгахад сургагч багш нарын материалгүй зэрэг бичиг баримтын бүрдүүлэлт, түүнд тавих хяналт хангалтгүй байгаа зөрчил илэрснийг аудитын явцад арилгууллаа.

“Архангай МСҮТ”, “Дарь овооны эзэд” ТББ-ын сургалтын төлөвлөгөөг холбогдох байгууллагаар батлуулаагүй байна.

Үйлдвэр дээрх сургалт зохион байгуулсан “Гост трейд” ХХК-д 7.2 сая төгрөгийн санхүүжилт олгосон боловч сургалтанд хамрагдсан ажилтнуудад чадамжийн гэрчилгээ олгоогүй байгаа нь ХХҮГ-тай байгуулсан гэрээний 3.7, 3.10.4-д заасныг зөрчсөн байна. Энэ нь гэрээний хэрэгжилтэнд ХХҮГ-аас тавих хяналт сул, гэрээг дүгнэж хариуцлага тооцоогүйтэй холбоотой байна.

График 3.



**1.2.2** Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс баталсан төсөл хөтөлбөрийн санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан ч анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байна.

2018 оны тухайд:

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс 8 хөтөлбөр, бусад арга хэмжээний зардалд зориулж 1,283,792.2 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 96 хувь буюу 1,233,500.0 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулжээ. Үүнээс хүүгүй 24-36 сарын хооронд эргэн төлөх 900.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг 194 иргэнд олгосон байна. Үүнийг анхан шатны баримтаар тулган шалгахад дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

1. Аж ахуй эрхлэлтийн сургалтанд хамрагдсан байх шалгуур үзүүлэлтийг хангаагүй;
2. Төслийн танилцуулга болон фото зураг байхгүй;
3. Барьцаа хөрөнгөгүй;
4. Сум, багийн Засаг даргын тодорхойлолт, амьжиргаа дэмжих зөвлөлийн шийдвэргүй
5. Төслийн санхүүжилтийн 70 хувийг тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл худалдан авахад зарцуулаагүй
6. Өрхийн гишүүний бичиг баримт, малын “А” данс зэргийг нотариатаар баталгаажуулаагүй
7. Хөтөлбөрт заасан шалгуурыг хангасан нотлох баримтгүй
8. Татвар, НДХ-т өргүй талаарх тодорхойлолтгүй зэрэг ХЭҮЗ-өөс баталсан хөтөлбөрт заасан шалгуур, шаардлага, ХНХСайдын тушаалаар баталсан удирдамжийн заалтыг зөрчсөн, аймгийн ХХҮГ-ын даргын баталсан удирдамжийг хэрэгжүүлээгүй зэрэг зөрчил илэрлээ.

2019 оны тухайд:

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс 7 хөтөлбөр, бусад арга хэмжээний зардалд зориулж 1,297,112.0 мянган



төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 92 хувь буюу 1,194,000.0 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулжээ. Үүнээс хүүгүй 24-36 сарын дотор эргэн төлөгдөх 787.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг 160 иргэнд олгосон байна.

Эдгээрээс эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг болон материаллаг дүнтэй ажил гүйлгээг түүвэрлэн шалгалаа. Аудитын явцад дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

Ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд батлан даагчийн баримт материалгүй 4 иргэнд 17.0 сая төгрөгийн санхүү дэмжлэг олгосон нь ХНХС-ын 2019 оны А/83 тушаалаар баталсан "удирдамж"-ийн 2.2.1.3.Б-д заасныг зөрчсөн байна.

Мөн 10 иргэнд барьцаа хөрөнгийн баталгааны баримтгүй санхүүгийн дэмжлэг олгосон нь аймгийн ХХҮГ-ын даргын баталсан удирдамжийн шаардлагыг зөрчсөн.

Ажил олгогчийн урамшуулалд ААНБ-ын улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, ажилтнуудын цалингийн картин хуулбарыг ирүүлээгүй 10 иргэнийг ажлаар хангасан гэх 5 ажил олгогчид 33520.0 мянган төгрөгийн урамшууллыг тооцож олгосон нь ХНХС-ын 2019 оны А/83 тушаалаар баталсан удирдамжийн 2.2.4.2-д заасныг зөрчсөн байна.

Дээрх 2 онд хөтөлбөрийн шалгуур шаардлагыг хангаагүй, шаардлагатай баримт материалыг бүрдүүлээгүй иргэд, ААНБ-д санхүүгийн дэмжлэг, урамшуулал олгосон зөрчил илэрснийг таслан зогсоох талаар тодорхой арга хэмжээ авч биелэлтийг нотлох баримтын хамт ирүүлэх хугацаатай албан шаардлагыг хүргүүллээ.


## БҮЛЭГ 2.

**Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны үр дүнд төлөвлөсөн байнгын ажлын байр бодитоор бий болсон нь нотлогдохгүй байна.**

### 2.1. Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний үр дүнд 2018, 2019 онуудад шинээр 1290 ажлын байр бий болсон мэдээлэлтэй байна.

#### 2.1.1 Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээний үр дүнд байнгын ажлын байр бий болох боломжгүй байна.

##### 2018 оны тухайд:



Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах чиглэлээр аймгийн ХХҮГ-аас 3 ААН-тэй гэрээ байгуулан 10 сумдын 465 иргэдийг ганцаарчилсан сургалтанд, 1070 иргэнийг бүлгийн сургалтанд хамруулсан байна. Сургалтын үр дүнд байнгын ажлын байр бий болсон эсэхийг тулган шалгахад ганцаарчилсан сургалтанд ЕБС-ийн сурагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө мэдээлэл хүргэсэн тул ажлын байр бий болоогүй байна.

Мөн ХНХСайдын 2018 оны А/13 дугаар тушаалын 1.4-д “Энэхүү журмын 1.3-т заасан иргэн хүнсний эрхийн бичгийг авах эхний 6 сарын хугацаанд дараах болзолыг хангана”, 1.4.2-д “Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээнд хамрагдаж, зөвлөгөө авсан байх” гэсэн байх бөгөөд уг шалгуурыг хангахын тулд 10 сумын 1070 зорилтот иргэнийг бүлгийн сургалтанд хамруулсан бөгөөд ажлын байр бий болгоогүй байна.

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт нь байнгын ажлын байрыг бий болгох бус халамжинд хамрагддаг зорилтот




иргэдийн хамруулахад чиглэсэн нь уялдаагүй зохицуулалт болсон байна гэж үзлээ.

Иймд хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн, байнгын ажлын байр бий болгохын тулд дээрх сургалтыг үр дүнтэй чанартай зохион байгуулах арга хэмжээ авах зөвлөмж хүргүүллээ.

2019 оны тухайд:


График 5.



Энэ онд ажил мэргэжлийн чиг


**2.1.2.** Ажилд зуучлах үйлчилгээний дүнд 2018, 2019 онуудад байнгын 1290 ажлын байр бий болсон мэдээлэлтэй байна.

баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээний хүрээнд бүлгийн сургалтанд ЕБС-ийн 743 сурагч “мэргэжил бүхэн сайхан”, “би өөрөө хэн бэ”, “мэргэжлээ хэрхэн сонгох вэ” зэрэг сэдэвт сургалтанд хамрагдсан бол ганцаарчилсан зөвлөгөө өгөх сургалтанд 278 ажилгүй иргэн хөдөлмөрийн зах зээлийн талаар, анкет хэрхэн бөглөх, ажлын ярилцлаганд бэлтгэх зэрэг сэдэвт сургалтанд хамрагдсан байна. Сургалтын байгууллагатай байгуулсан гэрээний 1.4-д “сургалтанд хамрагдсан ажилгүй иргэдийг тохирох ажлын байранд зуучилна” гэж заасан боловч 278 иргэний хэдийг нь ажлын байранд зуучилсан нь тодорхойгүй байна. Энэ нь гэрээний хэрэгжилтийг дүгнэж үр дүнг тооцохгүй байгаатай холбоотой гэж үзлээ. Сургалтанд хөрөнгө зарцуулж байгаа боловч эцсийн үр дүн болох ажилгүй иргэн ажилтай болсон байх асуудал орхигдсон байна.



2018 оны тухайд:

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, ажил олгогч байгууллагаас 1144 ажлын байрны захиалга авч 1012 иргэнийг ажилд зуучилсанаар байнгын 736, улирлын 50, түр 226 ажлын байрыг тус тус бий болгожээ. /2018-2019 оны Ажилд зуучлах үйлчилгээний тайланг үндэслэв/



2019 оны тухайд:

2019 онд хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, ажил олгогч байгууллагаас 1015 ажлын байрны захиалга авч 970 иргэнийг ажилд зуучилсанаар байнгын 554, улирлын 37, түр 379 ажлын байрыг тус тус бий болгожээ. /2018-2019 оны Ажилд зуучлах үйлчилгээний тайланг үндэслэв/

2018, 2019 онуудад байнгын ажлын байранд зуучлуулсан иргэд тогтвортой ажиллаж байгаа эсэхийг Хөдөлмөрийн хэлтсийн **ЭЛЭМИЭС** (LMIS) программаар тулгалт хийхэд уг программд улсын хэмжээнд Архангай аймгийн харьяалалтай хүн ажлын байртай болсныг нэгтгэн бүртгэдэг тул зөвхөн тухайн орон нутгийн Хөдөлмөрийн хэлтсээр зуучлуулсан ажлын байрыг тусгаарлаж үзэх боломжгүй байна.

Мөн энэ программд аймгийн ХЭДС-аас санхүүгийн дэмжлэг авсан иргэд, үйлдвэр дээрх сургалтанд хамрагдсан иргэдийн нэрсийг байнгын ажлын байртай болсноор бүртгэж байна. Иймээс аймгийн ХХҮГ-ын хөдөлмөрийн хэлтсийн зуучлалаар нийт хэдэн иргэн байнгын ажлын байртай болсныг тодорхойлох боломжгүй байлаа.

Иймд уг программд сайжруулалт хийх шаардлагатай байгаа нь харагдаж байна. Өөрөөр хэлбэл зөвхөн аймгийн ХХҮГ-ын хөдөлмөрийн хэлтсийн зуучлалаар бий болсон ажлын байрны мэдээлэл, бий болсон ажлын байранд байнгын тогтвортой ажиллаж байгаа эсэх мэдээллийг аймгийн НДХ-тэй уялдуулж тайлагнадаг байх шаардлагатай байна.



## 2.2. ХЭҮЗ-өөс баталсан хөтөлбөрүүдийг хэрэгжүүлснээр төлөвлөсөн ажлын байр нэмэгдэж бодит үр дүн бий болсон нь нотлогдохгүй байна.

ХЭҮЗ-ийн баталсан хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх хүрээнд ажил олгогчийг урамшуулалд хамруулснаар 2018 онд 8, 2019 онд 13 ажилгүй иргэнийг, үйлдвэр дээрх сургалт зохион байгуулсан 2 ААНБ 12 иргэнийг, гэрээт малчин арга хэмжээг хэрэгжүүлснээр 2018 онд 27, 2019 онд 88 малчин нийт 148 ажилгүй иргэнийг байнгын ажлын байртай болгосон нотлох баримттай байна. Жич: Гэрээт малчдын НДШ, ЭМДШ-ийг ХЭДС-аас төлсөн байна.

№	Хөтөлбөрийн нэр	Хамрах хугацаа	Санхүүжилт олгосон		Хүснэгт №1
			Иргэний тоо	Мөнгөн дүн	Ажлын байр
					Төсөлд тусгасан
1	Ажлын байрыг дэмжих	2018	53	159.0	98
		2019	59	265.0	102
2	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	2018	65	300.0	130
		2019	64	290.0	128
3	Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	2018	11	76.0	22
		2019	15	150.0	31
4	ХБИ иргэний ажлын байрыг дэмжих	2018	17	50.0	17
		2019	12	55.0	18
5	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх	2018	5	15.0	5
		2019	10	27.0	10
	Орон нутгийн онцлог хэрэгцээнд зориулсан	2018	43	300.0	100
<b>НИЙТ</b>			<b>354</b>	<b>1687.0</b>	<b>661</b>

Дээрх хүснэгтээс харвал нийт 354 иргэнд олгосон 1687.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийн үр дүнд 2018 онд 372, 2019 онд 289 нийт 661 шинэ ажлын байр бий болохоор байна. Энэ хүснэгтэнд дурдсан ажлын байрыг бий болгосныг нотлох албан ёсны баримт буюу НДШ төлсөн баримт аймгийн ХХҮГ-т байхгүй, аймгийн НДХ-ээс гаргуулахаар хандсан боловч “албаны нууц” гэсэн шалтгаанаар гаргаж ирүүлээгүй тул байнгын ажлын байр болсныг нотолж чадаагүй болно. Өөрөөр хэлбэл дэд сангаас санхүүжүүлсэн төслүүд хэрэгжиж байгаа боловч төлөвлөсөн ажлын байр хангалттай бий болсон гэх албан ёсны баримтгүй байна. Үүнийг хөтөлбөр тус бүрээр авч үзвэл дараах байдалтай байна.

### Ажлын байрыг дэмжих хөтөлбөр

*“Хувиараа болон нөхөрлөл, хоршооны хэлбэрээр аж ахуй, бичил бизнес эрхлэн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчийг санхүүгийн болон бусад дэмжлэг, арга хэмжээнд хамруулж, байнгын ажлын байр бий болгох, ажил олгогчид урамшуулал олгох, ажлын байрыг хадгалах, ажил хайгч, оюутан, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад суралцагчийг түр ажлын байраар хангаж, орлого нэмэгдүүлэхэд чиглэгдсэн байна”*

2.2.1. Ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд санхүүжүүлсэн төслүүдийн төлөвлөсөн шинэ ажлын байрыг бүрэн бий болгосныг нотлох баримтгүй байна.

2018 оны тухайд:

35-с дээш насны хувиараа хөдөлмөр эрхлэгчид:

Ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 35-с дээш насны хувиараа хөдөлмөр эрхлэгчид олгох эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт сонгон шалгаруулсан 53 иргэнд 159,000.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос 4 иргэнийг сонгон төслийн хэрэгжилт, үйл ажиллагаатай танилцахад 3 иргэн нь төслийн санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан, үйл ажиллагаагаа явуулж байлаа. Харин арьс суран эдлэлийн чиглэлээр 3.0 сая төгрөгийн санхүүжилт авсан иргэн Улаанбаатар хот руу явсан тул үйл ажиллагаатай нь танилцаж чадаагүй.



Дээрх 53 иргэн санхүүгийн дэмжлэг авч төсөл хэрэгжүүлснээр 98 ажлын байр бий болгоно гэж төсөлдөө тусгасан боловч байнгын ажлын байртай болж НДШ төлж байгааг нотлох баримт ХХҮГ-т байхгүй, аймгийн НДХ-ээс мэдээллийг гаргуулан авах гэсэн боловч “нууц” гэдгээр мэдээллийг гаргаж ирүүлээгүй болно. Ийнхүү ажлын байр бодитоор бий болсныг нотлох албан ёсны баримтгүй байгаа нь хөтөлбөрийн үр дүн бүрэн хангалттай гэж үзэх боломжгүй байна.

Мөн зээлийн эргэн төлөлт 2020 оны 06 сарын байдлаар 159,000.0 мянган төгрөгийг төвлөрүүлэхээс 98,229.5 мянган төгрөгийг төвлөрүүлж 38.2% буюу 60770.5 мянган төгрөгийн эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн төлөгдөөгүй байна.

2019 оны тухайд:

Энэ онд 59 иргэний төслийг сонгон шалгаруулж 265,000.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна. Эдгээр 59 хувиараа хөдөлмөр эрхлэгчид бизнес төслөө хэрэгжүүлснээр нийт 102 ажлын байр шинээр бий болгож, тоног төхөөрөмж хүчин чадлаа сайжруулж бизнесээ өргөжүүлэн, өрхийн үйлдвэрлэлээ нэмэгдүүлнэ гэсэн үр дүнг тооцоолон төсөлдөө тусгасан боловч байнгын ажлын байртай болж НДШ төлж байгааг нотлох баримт ХХҮГ-т байхгүй, аймгийн НДХ-ээс гаргуулан авах гэсэн боловч “нууц” гэдгээр мэдээллийг гаргаж ирүүлээгүй болно. Төсөл хэрэгжүүлэгчдээс түүврийн аргаар 5 иргэнийг сонгож төслийн хэрэгжилтийг газар дээр шалгахад 2 нь утас, хаяган дээрээ байгаагүй, “Арьсан урлал” төсөл хэрэгжүүлэгч Хасу худалдааны төвд лангуу түрээслэн борлуулдаг, “Хувцас оёдол” төсөл хэрэгжүүлэгч “999” худалдааны төвд ажлын байр түрээслэн ажилладаг, “Ургац” төсөл хэрэгжүүлэгч хүнсний ногоо тариалж 1-р 48-ийн дэргэдэх ногооны мухлагаар худалдаалдаг зэрэг төслөө хэрэгжүүлэн ажиллаж байна.

Эргэн төлөлтийн тухайд 28 иргэн 16838.9 мянган төгрөгийг эргэн төлөлтийн хуваарьт заасан хугацаанд төлөөгүй байна.

2018 оны тухайд:

**Ажил олгогчийн урамшуулал:**

Энэ хүрээнд 2018 онд 8, 2019 онд 13 нийт 21 иргэн байнгын ажлын байртай болсон байна.

2018 онд энэ хөтөлбөрийн хүрээнд ажил олгогчийг дэмжих урамшууллыг 8 иргэнийг байнгын ажлын байраар хангасан 6 байгууллагад 20,160.0 мянган төгрөг олгосон ба уг 8 иргэн тогтвортой ажиллаж байгаа эсэхийг тодруулахаар НДХ-т хандахад хариу ирүүлээгүй байна. Баримт материалыг тулган шалгахад 3 ажил олгогч улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, ажилтанд цалин олгосон цалингийн картны хуулбар зэргийг ирүүлээгүй баримтын бүрдүүлбэр дутуу байхад дэмжлэгийг олгосон нь ХЭҮЗ-ийн 2017.01.27-ны өдрийн 01 дүгээр тогтоолын хавсралтаар батласан Ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн 7.2, 7.6 дахь заалтыг зөрчсөн байна.



2019 оны тухайд:

Энэ хөтөлбөрийн хүрээнд ажил олгогчийг дэмжих урамшууллыг 13 иргэнийг байнгын ажлын байраар хангасан 6 байгууллагад 43360.0 мянган төгрөг олгосон байна. Ажилгүй 10 иргэнийг ажлаар хангасан 5 ААНБ нь улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, ажилтнуудын цалингийн картны хуулбарыг ирүүлээгүй байхад 33520.0 мянган төгрөгийн



урамшууллыг тооцож олгосон нь ХНХС-ын 2019 оны А/83 тушаалаар баталсан удирдамжийн 2.2.4.2-д заасныг зөрчсөн байна.

Дээрх зөрчлүүдийг таслан зогсоож, ажлын байранд тогтвортой ажиллаж байгааг нотлох баримтыг холбогдох байгууллагаас гаргуулан авч, хянаж байх албан шаардлагыг хүргүүллээ.

### **Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох**

*“Иргэдийг хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээ болон хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох сургалтанд хамруулж хөдөлмөрийн зах зээлд бэлтгэн, ажлын байранд дадлагажуулах замаар хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд хөтөлбөрийн зорилго оршино.”<sup>1</sup>*

**2.2.2** Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох сургалтаар шинэ ажлын байр бий болсон эсэхийг тооцох боломжгүй, харин үйлдвэр дээрх сургалтын үр дүнд 12 шинэ ажлын байр бий болсон байна.

#### 2018 оны тухайд:

Тухайн онд хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох чиглэлээр 193 иргэнд сургалт зохион байгуулсан байна.

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, ажлын байр үйлдвэрлэлтэй танилцах сургалтанд 105 иргэнийг хамруулсан ба энэ сургалт нь гэрчилгээ батламж олгодоггүй 3 өдрийн сургалт байна. Харин үйлдвэрлэл дээрх сургалтанд 7 иргэнийг мөн мэргэжлийн болон давтан явуулын сургалтанд 81 иргэнийг хамруулж чадамжийн гэрчилгээ олгожээ. Сургалтанд хамрагдсан иргэд байнгын ажлын байраар хангагдсан талаарх баримт аймгийн ХХҮГ-ын хөдөлмөрийн хэлтэст байхгүй нь хөтөлбөрийн үр дүнд ажлын байр нэмэгдсэн шинээр бий болсон эсэхийг тооцох боломжгүй байна.

#### 2019 оны тухайд:

Энэ онд гэрчилгээ батламж олгодоггүй 3 өдрийн хөдөлмөрт бэлтгэх сургалтанд 105 иргэнийг хамруулсан байна. Харин мэргэжлийн болон давтан сургалтанд 98 хүнийг хамруулж чадамжийн гэрчилгээ олгожээ. Сургалтанд хамрагдсан иргэд байнгын ажлын байраар хангагдсан талаар мэдээлэл баримт аймгийн ХХҮГ-ын хөдөлмөрийн хэлтэст байхгүй нь ХЭҮЗ-ийн 2019 оны 01 тогтоолын 1-р хавсралтын 7.2-д заасан хөтөлбөрийн үр дүнд хүрсэн эсэхийг тооцох боломжгүй байна. Үйлдвэр дээрх сургалтанд 36 иргэн хамруулснаас 16 иргэнд чадамжийн гэрчилгээ олгосон, 20 иргэнд гэрчилгээ олгоогүй ба сургалт зохион байгуулсан Гост трейд ХХК нь 9 иргэнийг, Газрын гагнаас ХХК 3 иргэнийг ажлын байраар хангасан нь уг хөтөлбөрийн 7.2.3-д “...сургалтанд хамрагдсан иргэдийн 40-с доошгүй хувь нь ажлын байртай болсон байна” гэснийг хангахгүй байна. Иймд үйлдвэр дээрх сургалт зохион байгуулсан Газрын гагнаас ХХК-иар хөтөлбөр болон гэрээний үүргийн биелэлтийг хангуулах арга хэмжээ авах албан шаардлагыг хүргүүллээ.

### **Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр**

*“Залуучуудыг хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд хамруулах, аж ахуй, биенес эрхлэх ур чадвар, шинэлэг санаанд тулгуурлан гарааны бизнесээ тогтвортой эрхлэхэд туслах замаар тэдний хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд хөтөлбөрийн зорилго оршино”<sup>2</sup>*

<sup>1</sup> ХЭҮЗ-ийн 2017 оны 01, 2019 оны 01 дүгээр тогтоолын 1-р хавсралтын 1 дэх заалт

<sup>2</sup> ХЭҮЗ-ийн 2017 оны 01, 2019 оны 01 дүгээр тогтоолын 3-р хавсралтын 1 дэх заалт



**2.2.3** Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд төсөлд шинэ ажлын байрыг бүрэн бий болгосныг нотлох баримтгүй байна.

2018 оны тухайд:

2018 онд залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд гарааны бизнес эрхлэлтийг дэмжих чиглэлээр 4 иргэнд 40,000.0 мянган төгрөгийн, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгч болон төгсөгчдийн бүлгийн 6 иргэнд 33,000.0 мянган төгрөгийн 3 жилийн хугацаатай эргэн төлөлттэй санхүүгийн дэмжлэг олгосон байна. Энэ хөтөлбөрийн хүрээнд олгосон дэмжлэгийн эргэн төлөлт 2020 оны 06 сарын байдлаар 53,976.0 мянган төгрөгийг төвлөрүүлэхээс 65.1% буюу 35150.0 мянган төгрөг нь хугацаа хэтэрсэн төлөгдөөгүй байна. Дээрхи 10 залуучууд бизнес төслөө хэрэгжүүлснээр нийт 22 ажлын байр шинээр бий болгож, тоног төхөөрөмж хүчин чадлаа сайжруулж бизнесээ өргөжүүлэн гэсэн үр дүнг тооцоолжээ. Төсөл хэрэгжүүлэгч иргэдээс түүвэрлэн 2 иргэнийг сонгон үйл ажиллагаатай нь танилцахад төслөө хэрэгжүүлж байгаа бөгөөд зориулалтын дагуу зарцуулсан байна.

2019 оны тухайд:

Энэ онд 15 бүлгийн төслийг сонгон шалгаруулж 150,000.0 мянган төгрөгийн, 3 жилийн хугацаатай эргэн төлөлттэй санхүүгийн дэмжлэг олгосныг анхан шатны баримтаар тулган шалгахад нэг бүлэг автомашин барьцаалсан, мөн нэг бүлэг барьцаагүй байгаа нь санхүүгийн дэмжлэг олгох гэрээний 5.6-д батлан даагч гэрээ байгуулах үнийн дүнгийн 100 хувьтай тэнцэх хэмжээний үл хөдлөх хөрөнгөөр батлан даана гэснийг зөрчсөн байна. Санхүүгийн дэмжлэгийг 2020 оны 01 сараас эхлэн эргэн төлөхөөр байгаа бөгөөд нийт 22333.4 мянган төгрөг төлөгдөхөөс 6997.2 мянган төгрөг төлөгдөж 15336.2 мянган төгрөгийн эргэн төлөлт хугацаа хэтэрсэн байна. Төслийг хэрэгжилтийг түүвэрлэн ЭБ суманд хэрэгжих 5 бүлгийн төслийн явцтай танилцахад 4 бүлэг төслөө хэрэгжүүлж санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан, харин 1 бүлэгтэй холбогдож чадаагүй болно. Энэ хөтөлбөрийн хүрээнд Санхүүгийн дэмжлэг авч төсөл хэрэгжүүлснээр 2018 онд 22, 2019 онд 31 байр шинээр бий болгоно гэж төлөвлөсөн боловч хичнээн байнгын ажлын байр бий болж НДШ төлж байгааг нотлох баримт ХХҮГ-т байхгүй буюу байнгын ажлын байр бий болсныг нотлох албан ёсны баримтгүй байна. Энэ нь Хөдөлмөрийн хэлтсийн зүгээс төслийн хэрэгжилт, эргэн төлөлтөнд байнга хяналт тавьж ажилладаг гэх боловч төслийн үр дүн буюу ажлын байранд анхаарал хандуулдаггүй, хяналт хангалтгүй гэж үзэхэд хүргэж байна.

**2.2.4** Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд байнгын ажлын байр бий болсныг нотлох баримтгүй байна.

*“Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар цөөн малтай болон малгүй иргэдийг ажлын байртай болгоход хөтөлбөрийн зорилго оршино.”<sup>3</sup>*

2018 оны тухайд:

Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт сонгон шалгаруулсан 15 сумын 65 малчинд 300,000.0 мянган төгрөгийн

<sup>3</sup> ХЭҮЗ-ийн 2017 оны 01, 2019 оны 01 дүгээр тогтоолын 4-р хавсралтын 1 дэх заалт





санхүүжилт олгосон байна. Малчин иргэдийн бизнес төсөлд 130 иргэнийг ажлын байраар хангана гэж тусгасан боловч байнгын ажлын байр бий болж НДШ төлж байгааг нотлох баримт ХХҮГ-т байхгүй.

Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт 2020 оны 06 сарын байдлаар 180,000.0 мянган төгрөгийг төвлөрүүлэхээс 95,580.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн ба нийт эргэн төлөлтийн 47.7 % буюу 85920.0 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн төлөгдөөгүй байна.

2019 оны тухайд:

Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт сонгон шалгаруулсан 18 сумын 64 малчинд 290,000.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна. Малчин иргэдийн бизнес төсөлд 130 иргэнийг ажлын байраар хангана гэж тусгасан боловч байнгын ажлын байр бий болж НДШ төлж байгааг нотлох баримт ХХҮГ-т байхгүй. Эргэн төлөлтийн тухайд 2020 оны 03 сараас эхний төлөлтүүд хийгдэж эхлэхээр байгаа бөгөөд 2020 оны сарын байдлаар 13500.0 мянган төгрөгийн эргэн төлөлтийг хугацаанд төлөөгүй нь ажиглагдлаа.

Харин малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд гэрээт малчин өрхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд 2018 онд 27, 2019 онд 88 малчин хамрагдаж тэдний НДШ, ЭМДШ-ийг ХЭДСангаас төлсөн байна.

2.2.5 Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд түүвэрт хамрагдсан иргэд ажлын байраар хангагдаж орлогоо нэмэгдүүлсэн байна.

*“ХБИ-ийг хөдөлмөрт бэлтгэх, дэмжлэгтэйгээр ажилд зуучлах, тэднийг аж ахуй эрхлэлт болон хөдөлмөр эрхлэх ур чадвар олгох сургалтанд хамруулах, урамшуулал, санхүүгийн дэмжлэг, хөдөлмөр эрхлэлтийн тусгай үйлчилгээ, арга хэмжээнд хамруулж дэмжлэг үзүүлэх замаар ХБИ-д зориулсан байнгын ажлын байрыг нэмэгдүүлэх, тэдний хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд хөтөлбөрийн зорилго оршино.”<sup>4</sup>*

2018 оны тухайд:

ХБИ-ний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд сонгон шалгаруулсан 17 иргэнд 50.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон ба эргэн төлөлт 2020 оны 06 сарын байдлаар 25,006.3 мянган төгрөгийг төвлөрүүлэхээс 16,275.4 мянган төгрөгийг төвлөрүүлсэн ба нийт эргэн төлөлтийн 35% нь хугацаа хэтэрсэн төлөгдөөгүй байна. ХБИргэний бизнесийн үйл ажиллагаанаас түүвэрлэн 2 иргэнийг сонгон үйл ажиллагаатай нь танилцахад төслөө хэрэгжүүлж байгаа бөгөөд зориулалтын дагуу зарцуулсан байна.

2019 оны тухайд:

Хөгжлийн бэрхшээлтэй 12 иргэнийг шалгаруулж 55.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон ба эргэн төлөлт 2020 оны 06 сарын байдлаар 13603.2 мянган төгрөгийг төвлөрүүлэхээс 11046.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн ба 2557.2 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн төлөгдөөгүй байна. Төсөл хэрэгжсэний дараах үр дүнг тооцохын тулд түүврийн аргаар ЭБ сумын 2 иргэнийг төсөлтэй танилцахад “Оёдол” төсөл хэрэгжүүлэгч иргэн хувцас оёж “Тайхар” худалдааны төвд лангуу түрээслэн ажиллуулдаг, “Модон эдлэл” төсөл хэрэгжүүлэгч иргэн

<sup>4</sup> ХЭҮЗ-ийн 2017 оны 01, 2019 оны 01 дүгээр тогтоолын 5-р хавсралтын 1 дэх заалт



гэрээрээ мужаан хийдэг, давхар цагаан идээ боловсруулж борлуулдаг байна. Түүвэрт хамрагдсан 2 иргэн төслөө хэрэгжүүлж өрхийн орлогоо нэмэгдүүлэн ажиллаж байгаагаас ХБИ-ний санхүүгийн дэмжлэг тодорхой хэмжээнд үр дүнгээ өгч байна гэж үзлээ.

**2.2.6** Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг дэмжих хөтөлбөрийн ажлын байр бий болж, өрхийн орлогоо нэмэгдүүлж байна.

*“Ахмад мэргэжилтнүүдийн хүсэлтэд үндэслэн ажил, хөдөлмөрт оролцох оролцоог нэмэгдүүлж, мэдээллийн сан үүсгэн, тэдний мэдлэг, ажлын туршлагыг өвлүүлэх, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх, өсвөр хойч үеийнхэнд хөдөлмөрийн дадал олгох чиглэлээр ажиллуулж орлогын дэмжлэг үзүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.”<sup>5</sup>*

2018 оны тухайд:

Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд 5 иргэнд өөрийн эзэмшсэн мэргэжлээр төсөл хэрэгжүүлж өрхийн орлогоо нэмэгдүүлэхэд зориулж 15,000.0 мянган төгрөгийн 2 жилийн хугацаатай эргэн төлөлттэй санхүүгийн дэмжлэг олгосон байна. Эргэн төлөлт 2020 оны 06 сарын байдлаар 15,000.0 мянган төгрөгийг төвлөрүүлэхээс нийт эргэн төлөлтийн 19% буюу 2850.0 мянган төгрөг хугацаандаа төлөгдөөгүй байна.

2019 оны тухайд:

ХЭҮЗ-ийн 2019 оны 1-р тогтоолын 6-р хавсралтаар баталсан "Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр"-ийн хүрээнд 10 ахмад настанд 1500-3000.0 мянган төгрөгийн нийт 27000.0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг 24 сарын хугацаанд эргэн төлөгдөхөөр олгосон байна.

Үүний үр дүнд 10 ахмад өрхийн үйлдвэр аж ахуй эрхэлж орлого нэмэгдүүлсэн байна. 2020 оны 6 сарын байдлаар 13500.0 мянган төгрөг төлөгдөхөөс 7445.0 мянган төгрөгийн эргэн төлөлт хугацаандаа төлөгдөөгүй байна

**Орон нутгийн хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төсөл:**

2018 оны тухайд:

Орон нутаг, нийслэлийн онцлог, хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төслийн хэрэгжилтийг хангах, зохион байгуулах, санхүүжүүлэх, хэрэгжүүлэхэд оролцогч талуудын уялдаа холбоог зохицуулахад энэхүү хөтөлбөр чиглэгдсэн байна. Уг хөтөлбөр нь зөвхөн 2018 онд хэрэгжжээ.

Сонгон шалгаруулсан 43 иргэнд 300,000.0 мянган төгрөгийн эргэн төлөлттэй зээл олгосон бизнес төсөл, баримт материалыг тулган шалгахад нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн хэмжээг тооцсон эсэх, Татвар, НДШ болон зээлийн өр төлбөргүй байх гэсэн нотлох баримтгүй шалгуур үзүүлэлтийг хангаагүй байхад 28 иргэнд санхүүгийн дэмжлэг олгосон зөрчил илэрлээ.

Дээрх 43 төслөөс 3 иргэний төслийг сонгон үйл ажиллагаатай нь танилцахад 2 иргэн нь УБхотруу явсан, үйл ажиллагаагаа явуулж буй нь тодорхой бус байлаа. Эргэн төлөлтийн тухайд 2020 оны 06 сарын байдлаар нийт 140686.0 мянган төгрөг төлөгдөхөөс 72254.0 мянган төгрөг хугацаандаа төлөгдөөгүй байна.

<sup>5</sup> ХЭҮЗ-ийн 2017 оны 01, 2019 оны 01 дүгээр тогтоолын 6-р хавсралтын 1 дэх заалт



Аймгийн ХЭД дэд сангаас дээрх хөтөлбөрүүдийн хүрээнд 2018 онд нийт 900.0 сая төгрөг, 2019 онд нийт 787.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон байх бөгөөд 2020 оны 6 сарын байдлаар нийт 700.3 сая төгрөг эргэн төлөгдсөн байх ёстойгоос 324.8 сая төгрөгийн эргэн төлөлт хийгдээгүй байна. Эргэн төлөлтийг эрчимжүүлэх талаар ХХҮГ-ын хөдөлмөрийн хэлтсээс зээлдэгч нарт сануулсан масс мессэж илгээх, гэрээний хугацаа дууссан иргэдэд мэдэгдэл өгөх, шүүхэд өгч шийдвэрлүүлэх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байгаа боловч эргэн төлөлт хангалтгүй байна.

### **БҮЛЭГ 3.**

**Аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөл нь ХЭҮЗ-ийн баталсан хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт шалгалт хийх, үр нөлөөг тооцох эрх, үүргээ хэрэгжүүлээгүй, мөн байгууллагын дотоод хяналтын үр нөлөө хангалтгүй байна.**

**3.1 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сангийн хөрөнгийн зарцуулалт, эргэн төлөлтөнд дотоод хяналтыг хэрэгжүүлсэн боловч үр нөлөө хангалтгүй байна.**

**3.1.1 Сангийн хөрөнгийн зарцуулалт, зээл, санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийн байдалд байгууллагын дотоод хяналт, шалгалт хийсэн боловч түүний мөрөөр үр дүнтэй арга хэмжээ аваагүй байна.**

#### 2018 оны тухайд:

ХХҮЕГ-ын хяналт мониторингийн газраас 2019 онд ХЭДСангийн 2017-2018 оны хөрөнгийн зарцуулалтанд дотоод хяналт шалгалт хийж, сургалтын байгууллагад 1.5 сая төгрөгийн илүү санхүүжилт олгосон, бусад байгууллагын хүсэлтээр 1.1 сая төгрөг зарцуулсан зэргээр Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, ХХҮЕГ-ын даргын тушаалаар баталсан зардлын жишиг хэмжээг баримтлаагүй зөрчлийг илрүүлж, зөрчил дутагдлыг давтан гаргахгүй байх талаар төлөвлөгөө гаргаж ажиллан биелэлтийг ирүүлэхийг зөвлөсөн байна.

Уг шалгалтаас өгсөн зөвлөмжийн биелэлтийг 2019 оны 12 сард хүргүүлэхдээ "ХХҮЕГ-ын даргын 2017 оны А/42 тушаалаар баталсан зардлын жишиг хэмжээг баримталж байна", "... сангийн хөрөнгийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд зориулалтын дагуу зарцуулж байна" гэснээс өөрөөр зөрчлийг арилгах талаар авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлсэн эсэх нь тодорхойгүй байгаа нь дотоод хяналт шалгалтын мөрөөр үр дүнтэй арга хэмжээ аваагүй гэж үзэхэд хүргэж байна.

#### 2019 оны тухайд:

2019 оны 11 сард аймгийн ХХҮГ-ын дотоод хяналт шинжилгээ үнэлгээ хариуцсан мэргэжилтэн ХЭДСангийн 2019 оны эхний 11 сарын гүйцэтгэлд хяналт шалгалт хийсэн байна.

Шалгалтаар санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан байна гэж үзсэн бөгөөд санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтүүд хангалтгүй байгааг илрүүлжээ.

Шалгалтын дүнгээс ХНХС-ын баталсан ХЭД үйлчилгээ арга хэмжээний нэгжид ногдох зардлын хэмжээг баримтлах, ХЭДС-ийн батлагдсан төсвийг хуваарийн дагуу бүрэн зарцуулах, эргэн төлөлтийг хугацаанд нь төлүүлэх арга хэмжээг зохион байгуулах, Гэрээний хугацаа дууссан иргэдийг шүүхэд өгч шийдвэрлүүлэх ажлыг эрчимжүүлэх зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Харин зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний ажлын тайланг гаргаагүй, биелэлтийг үнэлээгүй



байгаа нь ХХҮГ-ын хийсэн боловч үр дүн муутай байна гэж үзэхэд хүргэж байна. дотоод хяналт шалгалт

**3.1.2 Сангийн хөрөнгийн зарцуулалт, зээл, санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийн байдалд ХЭҮЗ, аймгийн ХЭЗ-өөс хяналт, шалгалт хийж үр дүнтэй арга хэмжээ аваагүй байна.**

ХЭҮЗ болон аймгийн ХЭЗ-өөс ХЭДС-ийн хөрөнгийн зарцуулалтанд ямар нэг хяналт шалгалт хийгээгүй байгаа нь ХЭҮЗ-ийн баталсан "аймаг дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлийн дүрэм"-ийн 2.1.5-д заасан "тухайн орон нутгийн хөдөлмөр эрхлэлт дэмжих дэд сангийн ... орлого, зарлагын байдалд хяналт тавьж, санхүүгийн тайланг хагас, бүтэн жилээр хэлэлцэж дүгнэлт гаргах" гэсэн эрх, мөн дүрмийн 2.2.3-д заасан "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сангийн орлого, зарлагын явц байдал, үүний дотор хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн жижиг зээлийн эргэн төлөлтийн байдалд хяналт тавих" гэсэн үүргийг хэрэгжүүлээгүй, дэд сангийн зарцуулалт, эргэн төлөлтөнд хяналт тавих үр дүнтэй арга хэмжээ аваагүй байна.

**3.2. Аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөл нь ХЭҮЗ-ийн баталсан хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт шалгалт хийх, үр нөлөөг тооцох эрх, үүргээ хэрэгжүүлээгүй байна.**

**3.2.1 Хөтөлбөрийн хэрэгжилтэнд байгууллагын дотоод хяналт шалгалт хийж хөтөлбөрийн зорилго үр дүнг хангах үр нөлөөтэй арга хэмжээ аваагүй байна.**

ХХҮЕГ-ын хяналт мониторингийн газраас 2019 онд ХЭДСангийн 2017-2018 оны хөрөнгийн зарцуулалтанд дотоод хяналт шалгалт хийж, ХЭҮЗ-өөс баталсан хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх хүрээнд олгосон санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт хангалтгүй буюу нийт 157727.0 мянган төгрөгийн эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн зөрчлийг илрүүлж, эргэн төлөлтөнд хяналт тавьж гэрээнд заасан хугацаанд багтаан төлүүлж ажиллах, төсөл хөтөлбөрийг ашиг сонирхолын зөрчилгүй зохион байгуулж байх, төслийн хэрэгжилтэнд явцын болон гүйцэтгэлийн хяналтыг тогтмол хийж үр дүн үр нөлөөг тооцон хэрэгжээгүй төслийн санхүүжилтийг буцаан татаж сангийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах зөрчил гаргахгүй байх талаар төлөвлөгөө гаргаж ажиллан биелэлтийг ирүүлэхийг зөвлөсөн байна. Гэвч уг зөвлөмжийн дагуу төлөвлөгөө гаргаж биелэлтийг хангуулан ажилласан тухай баримтыг аудитад хамруулаагүй, эргэн төлөлт хангалтгүй байгаа нь дотоод хяналт шалгалтын үр дүн хангалтгүй байна гэж үзлээ.

**3.2.2 Хөтөлбөрийн хэрэгжилтэнд аймгийн ХЭЗ-өөс хяналт шалгалт хийх, үр нөлөөг тооцох эрх үүргээ хэрэгжүүлээгүй байна.**

ХЭҮЗ болон аймгийн ХЭЗ-өөс ХЭДС-ийн хөрөнгийн зарцуулалтанд ямар нэг хяналт шалгалт хийгээгүй байгаа нь ХЭҮЗ-ийн 2017 оны 2 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлийн дүрэм"-ийн 2.2.4-д заасан "тухайн орон нутагт хэрэгжсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээ, хөтөлбөр төслийн үр дүн нөлөөлөлд жил бүр үнэлгээ хийж, санал дүгнэлт гаргах", мөн 2.2.8-д заасан "Тухайн орон нутагт хэрэгжсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээний үр дүн болон нөлөөлөлд хийсэн үнэлгээний тайланг ХЭҮЗ-д жил бүрийн 1 дүгээр сард ирүүлж байх" гэсэн үүргийг хэрэгжүүлээгүй, ХЭДС-аас хэрэгжүүлсэн хөтөлбөр арга хэмжээний үр дүнг хангах арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй байна.

Иймд ХЭҮЗ-өөс баталсан "аймаг, дүүргийн ХЭЗ-ийн дүрэм"-д заасан эрх үүргийг хэрэгжүүлж орон нутагт хэрэгжиж буй хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээ, хөтөлбөр төслийн үр дүнд хяналт тавьж, үр нөлөөнд үнэлгээ хийж, холбогдох арга хэмжээг авах зөвлөмжийг аймгийн ХЭЗ-д хүргүүлж байна.

-----oOo-----



## АУДИТЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сангийн түүвэрт хамрагдсан үйлчилгээ, арга хэмжээний санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан ч анхан шатны баримтын бүрдүүлэлт хангалтгүй байна.
2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлсэн төслүүдийн үр дүнд төлөвлөсөн байнгын ажлын байр бодитоор бий болсон нь нотлогдохгүй байна.
3. Аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөл нь ХЭҮЗ-ийн баталсан хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт шалгалт хийх, үр нөлөөг тооцох эрх, үүргээ хэрэгжүүлээгүй, мөн байгууллагын дотоод хяналтын үр нөлөө хангалтгүй байна.

Аудитын дүнгээс **“Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сангаас санхүүжүүлсэн төслүүд хэрэгжиж байгаа ч төлөвлөсөн ажлын байрыг хангалттай бий болгоогүй байна”** гэсэн ерөнхий дүгнэлтэнд хүрч байна.

Аудитаар нийт 324.6 сая төгрөгийн зөрчил илэрсэн бөгөөд зөрчлийг таслан зогсоох давтан гаргахгүй байх 2 албан шаардлагыг аймгийн ХХҮГ-т хүргүүллээ. Мөн аудитаар илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй байх дэд сангийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах, санхүүжүүлсэн төслийн хэрэгжилт үр дүнд үнэлгээ хийж түүнийг сайжруулах талаар үр ашигтай арга хэмжээ авч хэрэгжүүлэх зөвлөмжийг аймгийн ХЭЗ болон аймгийн ХХҮГ-т тус тус хүргүүллээ.

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

### **Аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлийн дарга Б.Болормаад**

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 2 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлийн дүрэм”-д заасан дараах эрх үүргийг хэрэгжүүлэх үр дүнтэй арга хэмжээ авахыг зөвлөж байна. Үүнд:

1. “... хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн жижиг зээлийн эргэн төлөлтийн байдалд хяналт тавьж эргэн төлөлтийг эрчимжүүлэх талаар шийдвэр гаргаж хэрэгжилтийг хангуулах
2. Орон нутагт хэрэгжиж буй хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээ, хөтөлбөр төслийн үр дүнд хяналт тавьж, үр нөлөөнд үнэлгээ хийж холбогдох арга хэмжээг авах
3. Орон нутагт хэрэгжсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээ, хөтөлбөр төслийн төслийн үр дүн, үр нөлөөнд хийсэн тайланг ХЭҮЗ хүргүүлж холбогдох шийдвэр гаргуулах зэрэг үр дүнтэй арга хэмжээ зохион байгуулж хэрэгжүүлэх

### **Аймгийн ХХҮГ-ын дарга Д.Мөнхбатад**


1. ХЭДСангаас санхүүжүүлэх үйлчилгээ, арга хэмжээний шалгуур, шаардлагыг хангах, анхан шатны баримтанд тавих хяналтыг сайжруулах ажлыг төлөвлөж хэрэгжүүлэх баримтын бүрдэлт дутуу үйлчилгээ, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх
2. Бусад байгууллагуудтай хамтран ажиллахаар байгуулсан гэрээнүүдийг дүгнэсний дараа санхүүжилт олгох, хариуцлага тооцох арга хэмжээг авч хэвшүүлэх
3. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтанд хамрагдсан иргэдийг ажлын байранд зуучлах сургалтын гэрээний үүргийг хэрэгжүүлж ажиллах
4. Ажлын байрны бүртгэлийг тодорхой ойлгомжтой болгох арга хэмжээ авах, бүртгэлийн программыг боловсронгуй болгох талаар оновчтой санал гаргаж ХХҮЕГ-т хүргүүлж шийдвэрлүүлэх
5. Санхүүжүүлсэн төслийн хэрэгжилтийн явцад болон гүйцэтгэлд жилд 1-ээс доошгүй удаа дотоод хяналт шалгалт хийж, шалгалтын үр дүнг үнэлж байх, төлөвлөсөн ажлын байр бий болгох гэрээний хэрэгжилтийг хангуулах, гэрээнд заасан хариуцлагыг тооцож, үр дүнг хангуулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх
6. Байнгын ажлын байраар хангагдсан талаарх мэдээлэл, баримт материалыг хамрагдсан байгууллагаас авахаас гадна Нийгмийн даатгалын хэлтсээс гаргуулан авч тулган баталгаажуулж байх

Зөвлөмжийн заалт бүрийн хэрэгжилтийг гаргаж 2020 оны 11 сарын 25-ны дотор холбогдох нотлох баримтын хамт Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.



## ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ

Аймгийн ХХҮГ-аас аудитын тайланд тусгуулах дараах саналыг ирүүлсэн байна.



**АРХАНГАЙ АЙМГИЙН  
ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР**

65141 Архангай аймаг, Эрдэнэбулган сум,  
Утас/Факс: (976) 7033 2583,  
И-мэйл: info@arkhangai.hudulmur-halamj.gov.mn

2020.07.20 № 232  
танай 2020.07.16 -ны № 348 -Т

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
Д.УЛАМБАЯР ТАНАА

*Д.Уламбаяр*  
*Тайлангийн төсөлд санал*

Тайлангийн төсөлд санал,  
тайлбар өгөх тухай

Архангай аймаг дахь Төрийн Аудитын газрын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үр дүнд ажлын байр нэмэгдсэн байдал"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаж дараах санал тайлбар нотлох баримтыг хүргүүлж байна. Үүнд:

1. "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сангаас санхүүжүүлсэн төслүүд төлөвлөсөн ажлын байрыг бий болгоогүй" гэж Аудитын байгууллагаас дүгнэжээ. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас малчин, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч, хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнд ганцаараа болон бусадтай хамтран аж ахуй эрхлэхэд нь зориулж 3.0-5.0 сая.төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг олгож, өөрөө өөртөө болон бусадтай хамтран хөдөлмөр эрхэлж байгаа боловч ажлын байр бий болгоход хангалттай хэмжээний хөрөнгө оруулалт болж чадахгүй байгаа нь улс орны нийгэм эдийн засгийн байдал, бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт, иргэдийн худалдан авах чадвар зэргээс ихээхэн хамаарч байгаа зэргийг харгалзан үзэх нь зүйтэй байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрт хамрагдсан иргэд хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа боловч нийгмийн даатгалын шимтгэлийг төлж чадахгүй байгаа нь хангалттай хэмжээний орлого орж чадахгүй, мөн жилээс жилд нэмэгдэж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс хамаарсан нийгмийн даатгалын шимтгэл өндөр зэргээс шалтгаалж байна.

2. Тус газар нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн эргэн төлөлтийг эрчимжүүлэх чиглэлээр сар бүр иргэдэд эргэн төлөлтөө хийхийг сануулсан масс мессэж үйлчилгээ, гэрээний хугацаа дууссан иргэдэд мэдэгдэл өгөх, шүүхэд өгч шийдвэрлүүлэх зэрэг олон арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна.

Гэвч 2020 онд Дэлхий нийтэд тархаад байгаа "Ковид-19" коронавирусуус урьдчилан сэргийлэх зорилгоор Монгол улсын Засгийн газар сүүлийн хэдэн сар хөл хорио тогтоож, нийгэм эдийн засгийн хүнд нөхцөл байдалд хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн үйл ажиллагаа зогсонги байдалд орж, бараа бүтээгдэхүүн борлуулалт, үйлчилгээний орлого буурснаас иргэд санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийг цаг тухайд нь төлж чадахгүй байна. Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн малжуулах арга хэмжээнд хамрагдсан малчин өрх байгалийн давагдашгүй хүчин зүйлс зуд, малын хавдарт өвчний улмаас худалдаж авсан мал нь хорогдон эргэн төлөлтөө төлж чадахгүй байгаа зэрэг өргөдөл гомдол манай байгууллагад ирсээр байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн эргэн төлөлтийн хэмжээ жилээс жилд нэмэгдэж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөр




хариуцсан мэргэжилтнүүд үндсэн ажил төсөл хөтөлбөрөө хэрэгжүүлэхээс илүүтэй банкны ажилтан шиг эргэн төлөлтийн араас хөөцөлцөх ажил нь ихсэж байна.

Тус газар нь дээрх хүндрэл бэрхшээлээс шалтгаалан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн эргэн төлөлтийн ажлыг эрчимжүүлэхэд бэрхшээлтэй байгааг дурьдах нь зүйтэй.

3. “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сангаас санхүүжүүлсэн төслүүд төлөвлөсөн ажлын байрыг бий болгоогүй” гэсэн дүгнэлтийг бодит нөхцөл байдалд үндэслэн “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сангаас санхүүжүүлсэн төслүүд хэрэгжиж байгаа боловч төлөвлөсөн ажлын байрыг хангалттай бий болгоогүй байна” гэсэн дүгнэлтээр өөрчлөх саналтай байна.

Хавсралтаар иргэдээс ирсэн өргөдөл гомдлыг хүргүүлэв.



Уг тайлангийн төсөлд ирүүлсэн тайлбар саналыг судалж үзээд дараах арга хэмжээг авлаа. Үүнд:

1. Тайлбар саналын 1-рт дурдсан “... хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрт хамрагдсан иргэд хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа боловч нийгмийн даатгал төлж чадахгүй байгаа нь хангалттай хэмжээний орлого орж чадахгүй, мөн жилээс жилд нэмэгдэж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс хамаарсан нийгмийн даатгалын шимтгэл өндөр зэргээс шалтгаалж байна.” гэснийг хүлээн авч аудитын тайланд тусгалаа.
2. Тайлбар саналын 2-рт дурдсан “... тус газар нь ... эргэн төлөлтийг эрчимжүүлэх чиглэлээр сар бүр иргэдэд эргэн төлөлтөө хийхийг сануулсан масс мессеж үйлчилгээ, гэрээний хугацаа дууссан иргэдэд мэдэгдэл өгөх, шүүхэд өгч шийдвэрлүүлэх олон арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна” гэснийг хүлээн авч тайланд тусгалаа.
3. Санал тайлбарын 3-рт дурдсан дүгнэлтийг өөрчлүүлэх саналыг хүлээн авч “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сангаас санхүүжүүлсэн төслүүд хэрэгжиж байгаа боловч ажлын байрыг хангалттай бий болгоогүй байна” гэсэн дүгнэлтийг хийлээ.
4. Хавсаргаж ирүүлсэн өргөдөл нь зээлийн эргэн төлөлтийн хугацаа хойшлуулах хүсэлт тавьсан асуудал байгаа нь манай байгууллагад хамаарахгүй асуудал буюу ХХҮГ-ын өөрийн шийдвэрлэх асуудал байна. Иймд өргөдлийг хүлээн авах шаардлагагүй гэж үзлээ.

-----oO-----





## Тайлан баталгаажуулсан тушаал



### АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2020 оны 07 сарын 21 өдөр

Дугаар А/18

Цэцэрлэг

Гүйцэтгэлийн аудитын тайлан  
баталгаажуулах тухай

Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2018 оны 11 сарын 19-ний өдрийн А/207 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 1.3, 2.4 дэх заалтууд, 2016 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн А/92 дугаар тушаалаар батлагдсан "Гүйцэтгэлийн аудитын журам"-ын 12 дугаар зүйлийн 40 дэх заалт, Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын Удирдлагын зөвлөлийн 2020 оны 07 сарын 21-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сангийн үйл ажиллагааны үр дүнд ажлын байр нэмэгдсэн байдал"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитаар өгсөн албан шаардлагыг хавсралтаар баталгаажуулсугай.
3. Аудитын тайланг аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөл, ХХҮГ-т болон аймгийн ИТХ-ын дарга, Засаг дарга нарт тус тус хүргүүлсүгэй.
4. Гүйцэтгэлийн аудитын тайланд тусгагдсан зөвлөмж, өгсөн албан шаардлагын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг гүйцэтгэлийн аудитын багийн ахлах аудитор Д.Нэргүйбаатарт даалгасугай.


ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.УЛАМБАЯР



Архангай аймаг Төрийн Аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторын  
2020 оны 07 сарын 21-ны өдрийн ..... тоот тушаалын хавсралт



“Улсын төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашгийг-т  
хийсэн аудитаар өгсөн албан шаардлагын жагсаалт”

№	Албан шаардлагын		Албан шаардлагын огноо, дугаар	Албан шаардлагын хэрэгжилтийг хариуцах	
	Утга	Мөнгөн дүн /сая төг/		Байгууллага, албан тушаал	Албан тушаалтны нэр
1	Зөрчил арилгуулах тухай	324.6	10/130 АРА-2020/02-ГА	ХХҮГ-ын дарга	Д.Мөнхбат
2	Зөрчил арилгуулах тухай		10/131 АРА-2020/02-ГА	ХХҮГ-ын дарга	Д.Мөнхбат